



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/215

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "БҮТЭЭЛЧ-ӨВӨРХАНГАЙ-2020" хөтөлбөрийн 3.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 3.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Мобиком корпорацийн хамтран хэрэгжүүлдэг орон нутгийн сургуулийн "Ариун цэврийн байгууламж" төсөлд хамрагдахаар төлөвлөгдсөн тул энэхүү төсөлд 30,000,000 (гучин сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Дээрх 30,000,000 (гучин сая) төгрөгийн зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011100487